

НАРИЙНТЭЭЛ СУМЫН “ОНХС –ИЙН ГҮЙЦЭТГЭЛ” СЭДЭВТ ТӨСВИЙН ХЯНАЛТ
НИЙТИЙН СОНСГОЛ ХИЙСЭН ТЭМДЭГЛЭЛ

2023.11.03

Цагаан-овоо

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Нарийнтээл сумын ОНХС –ийн гүйцэтгэл сэдэвт нийтийн сонсголд оролцогчоор 4 иргэн хүсэлт ирүүлснээс 4 иргэн, ААНБ –ын төлөөлөл, ажиглагчаар 14 иргэн, ААНБ-ын төлөөлөл хүсэлт ирүүлж, урилгаар заавал байх ёстой 13 албан тушаалтанд 2023 оны 10 сарын 19 –ний өдөр албан мэдэгдэл хүргүүлснээс 11 албан тушаалтан, хэвлэл мэдээллийн төлөөлөл 1 мэргэжилтэн оролцож сонсголыг Соёлын төвд 2023 оны 11 дүгээр сарын 03 –ний өдрийн 11:41 цагт сонсгол удирдагч даргаар ИТХ ажлын албаны Нарийн бичгийн дарга Н.Сайнбилэг удирдан сонсголд оролцогчдын бүртгэл, ажиглагчдын бүртгэл, заавал оролцох албан тушаалтнуудын бүртгэлийг дуудаж, дэгийг танилцуулан сонсголыг нээж эхлүүлэв.

СОНССОН НЬ:

ОНХС –ийн гүйцэтгэл 2022 , 2023 он сэдэвт нийтийн сонсголд мэдээлэл хийх албан тушаалтан П.Сольтогтох төсвийн зарцуулалттай холбоотой мэдээллийг танилцуулав. Хүнсний зорь 40сая, хөгжлийн төлөвлөгөө 36,6сая, түүх соёлын танхим 10,8сая, СӨББ худаг 20сая, Халуун усны хашаа 1,19 сая, хогийн цэгийн өргөтгөл 8,25сая, Тэжээлийн нөөц 14сая, бэлчээрийн худаг 20сая, Тээлийн улаан ямаа 20сая, гэх мэт хийгдсэн ажлын зурагт слайд бүхий илтгэл танилцуулав.

Сангийн сайдын 2021оны 05 дугаар сарын 24 ний өдрийн 86 дугаар тушаалаар батлагдсан журмын хүрээнд иргэдээс ирүүлсэн санал, БИНХ-аар эрэмблэгдсэн жагсаалтаар ажлууд хэрэгжиж байгаа.

2023 он ЭМТ ариун цэврийн байгууламж, Архивын нягтруулах шүүгээ, Соёлын төвийн номын сангийн тохижилт, малын лаборатори төхөөрөмж, трактор 45сая үлдэгдэл, тракторын бутлагч, борно авах, нийт 207804мян.төг төсөвлөгдсөнөөс одоо хийгдсэн ЭМТ 2 шатаах зуух , Ариун цэврийн байгууламж, 45 сая , Архивын нягтруулах шүүгээ 12.9900 мян.төг , Соёлын төвийн Номын сангийн тохижилт зарлагдсан, Баянтээг гэрэлтүүлэг 19,1 сая гарсан, Цагаан – овоо иргэний танхим зарлагдсан, Шарга багийн төвийн засвар С.Батдорж гүйцэтгэж байгаа. ЕБС сан техник хийгдсэн, худаг цэвэршүүлэгч тавих ажил хүлээгдэж байгаа. Үхэр тарилга 15 саяас, Трактор 31 олгогдсон. Нийт 27 төсөл арга хэмжээнд 593479,3 мян.төг –ийн төсөл арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. МАА албан татвар 36609,9мян.төг төвлөрсөн байсан гэснээр мэдээллийг дуусгав.

АСУУЛТ: Оролцогч А.Батдорж:

1. Соёлын төвийн түүхийн музей тухай үед гүйцэтгэл хийгдсэн ажил 2022 онд яагаад 50% гүйцэтгэлтэй байна уу?

2. Цамхаг гэрлүүд яагаад жил хүрэхгүй шатаад байгаа эсэх, баталгааны хугацаа байгаа юу?

ХАРИУЛТ: Сумын Засаг дарга Б.Сугар: - 1. 2022 оны ажил 2021 онд 40 гаруй сая төгрөгийн төсөл анх явсан шийдэгдээгүй үлдсэн. 2022 онд бага хэмжээний мөнгө батлагдсан 10сая төгрөг тухайн үед соёлын төвийн эрхлэгч солигдож ажил

завсардсан. Тухай үед ажлын хэсгийг байгуулж үнэлгээний хороо тендерийг зарлаад явсан. Тухайн үед 45сая төгрөгийн төсөвт төслийг хүргүүлсэн энэ дагуу 10 сая гаруй төгрөгдөө нэг өрөө тохижуулахаар байсан. Сүүлд 3 өрөө болсон байсан. Тендерийг 3 удаа зарлаад хүн ороогүй, сүүлд Отгонбаатар иргэнтэй гэрээ хийсэн. 50% санхүүжилт олгогдсон хэдий ч санхүүжилт нь хүрээгүйн улмаас ажил дутуу явагдаад ажлаа гүйцээж дутуу санхүүжилтээ авч чадаагүй байгаа. Хугацаа явах өнгөрөх тусам бараа материалын үнэ өсөх зэрэг шалтгаанаар материалаа татаж чадахгүй ажил зогсоод байгаа. Цаашид гэрээг цуцлах асуудлыг орон нутгийн өмчийн газраас зөвлөгөө мэдээлэл туршлага солилцож шийдвэрлэхээр хөөцөлдөж байгаа.

2. Гэрэлтүүлэг баталгаат хугацаа байгаа. баруун талын гэрэл сардаа дангаараа 100мянга гаруй төгрөгийн зардал гаргадаг, мөн сум орон нутагт ТҮК байхгүй хариуцах хүнгүйдээд байгаа. Тухайн асуудлыг дээд шатны байгууллагад тавьж байгаа. Одоогоор цахилгаан хариуцсан мэргэжилтнээр засвар үйлчилгээг хийхээр яригдаж байгаа.

П.Сольтогтох: Он гараад бүх тендер бүх төсвийг мэргэжлийн төсөвчнөөр хийлгэхээр “Орон нутгийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай” хуульд өөрчлөлт орсон байгаа. гэрэлтүүлэг баталгаат хугацаа 2 жил гэж гэрээнд заасан байна.

АСУУЛТ: Оролцогч Д.Данаасүрэн: ОНХС – иргэд санал өгүүлээгүй гэх иргэдээс гомдол гарч байна.

ЭМТ шатаах зуух хавар хурлаар нэмэгдсэн юм уу?

3. Нийт мөнгө яаж хуваарилж байна ?? ирсэн төсөвтөө тааруулж хувааж байна ?, тооцоо судалгаа хийж байна уу?

ХАРИУЛТ: П.Сольтогтох:иргэдэд багийн засаг дарга, ИТХ-ын төлөөлөгчид саналын хуудас тарааж саналыг авдаг байгаа. БИНХ –аар эрэмбэлүүлж хэрэгжүүлдэг байгаа.

АСУУЛТ: Оролцогч Ц.Ганхуяг: 1. 10854мянган төгрөг 50% олгогдсон байна. Гэрээний үнэлэлт, дүгнэлт байна уу ?,

2. ОНХС –аар хийгдсэн хяналт, тайлангаар санхүүжилт олгогддог журамтай хэрэгжиж байнга уу?

3. үнэлгээ хийж гарын үсэг зурдаг уу?

4. техникийн тодорхойлолт боловсруулж хэрэгжүүлэх ажил байгаа юу?

5. Төсөв батлахдаа соёлын төвд 30сая.төг баталсан, одоо нэр өөрчлөгдөөд номын сангийн тохижилт, хаягжуулах ажил гэж орж ирсэн байна.

6. Малын тоо толгойн албан татварыг яаж төвлөрүүлэхээр тооцож байгаа бэ?

ХАРИУЛТ: П.Сольтогтох: 1.Сумын Засаг даргатай гэрээ байгуулсан ажлуудад хяналтын тайланг авч хавсаргаж санхүүжилт олгож байгаа.

2. Татварын байцаагч байхгүй 7 сар болж байгаа. Малчдад албан мэдэгдлээ хүргүүлсэн. БЗД, төрийн сангийн мэргэжилтэн бүгд араас нь чадахаараа хөөцөлдөж байгаа.

ЗДТГ-ын дарга Б.Ичинноров: Татварын алба данс барих болоод бусад хэрэгжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэхгүй байна. Татварын алба гүйцэтгэх ажилбараа хэрэгжүүлэхгүй байгаатай холбогдолтой байна.

Сумын Засаг дарга Б.Сугар:

1. Гэрээг дүгнэж байгаа. Иргэний тухай хуульд заасан дагуу гэрээ цуцлагдаж байгаа. Иргэний тухай хууль 355.5 дахь заалтаар хэрэгжүүлсэн.

3. техникийн тодорхойлолтоор тусгагдсан асуудлаар хяналт байнга ажлын хэсэг ажиллаж байгаа. иргэний танхим дээр тамбар хасагдсан гэсэн надад мэдээлэл ирээгүй байгаа.

4. Соёлын төвийн түүх соёлын танхим тохижуулах гэсэн нэрээр орсон. Бараа үйлчилгээг салгах гэдгээр оруулсан.

АСУУЛТ: А.Төмөрбаатар: Сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө хэзээ бэлэн болох бэ?

ХАРИУЛТ: Б.Сугар: Энэ 11 сард багтаагаад хүлээлгэж өгөхөөр шийдэлтэй байгаа.

АСУУЛТ 2: Аварга Цэрэнтогтохын нэрэмжит танхимын ажил гүйцэтгэлээ 50% хийгдсэн гэсэн үнэлгээ хэн өгөөд, яаж үнэлээд байна ?, дүгнэлт баримт материал байна уу?

3. Соёлын төв олон хүн цугладаг газар. Зөвшөөрөлгүй өөрчлөх үндэслэл байсан уу?

Байгалийн гамшиг болох эрсдэл гарвал энэ засах

4. Сумын ЭМТ ариун цэврийн байгууламж 25 байсан тодотголоор 45 сая болгосон. Гэтэл одоо гадаа газар шорооны ажил байхгүй, бөглөөс гаргаад болно. ИТХ-ын ажлын хэсэг хяналтаар очсон техникийн тодорхойлолт байхгүй. Тийм үнэтэй бөглөөс гаргах ажил хийсэн юм уу?

5. үнэлгээний хорооны бүрэлдэхүүний чадвар муу байна гэж үзлээ. Техникийн тодорхойлолт байхгүй, үнийн санал бага гэсэн үндэслэлээр тендер аваад байна шүү. Яаж шийдвэрлэх бэ?

6. Тухай тендер шалгарсан материалыг татаж авч өгч болох уу?

ХАРИУЛТ: Ш.Ууганбаяр: - Тухайн үед хариуцаж байсан /Соёлын төвийн эрхлэгч/

Нийт эхний санхүүжилт 5.4 сая төгрөг орж ирсэн. 90.0 мян.төг татварт үлдээд 5.1 сая төгрөгийн төсвөөр хэрэгжсэн. 2 сая гаран төгрөгийн бараа материал авсан. /1.933.500 төг/ Тухайн үед тендер хэд хэд зарлагдаад хүн ирээгүй ашиггүй гэж үзээд байсан. Тиймээс аж ахуйн аргаар хийж эхэлсэн хэдий ч ажлын хөлс нь 3.1 сая төгрөгийн үнэлгээтэй байсныг хүртэл материалд зарцуулаад үндсэндээ 5 сая гаран төгрөгийн төсөв зарцуулаад 50% -ийн санхүүжилтээсээ даваад явсан. Нэмээд 50% -ийн санхүүжилтээ авах санал тавьсан ч боломжгүй болж ажил зогсоосон байна.

Б.Сугар: ЭМТ –ийн бохирын ажил нэлээд төвөгтэй байсан. Ажлын даалгаврыг гаргаж ирүүлэхийг ажлын хэсэгт үүрэг болгосон хэдий ч чадаагүй. Мэргэжлийн байгууллага авч ирүүлж үнэлгээг хийлгэсэн. Стандартын дагуу тодорхойлолт гаргаж ирүүлсэн.

Техникийн тодорхойлолт байхгүй тендер гараагүй байгаа. бүгд техникийн тодорхойлолт, мэргэжлийн байгууллагын тодорхойлолт үндэслэж ганц үнийн бага санал гэж баримталдаггүй байгаа.

П.Сольтогтох: Бүх тендер цахимаар зарлагдахаар заавал баримт материалыг хэвлэх шаардлагагүйгээр архивлаж байгаа.

АСУУЛТ: А.Батдорж нэмэлтээр: - Мал эмнэлэг дээр үйлчилгээний хөлс нэмэх шаардлага байна уу?

ЭМТ –ийн шатаах зуух төв дотроо байрлаж болж байна уу?.. хортой хог хаягдалд ордог баймаар юм.

ХАРИУЛТ: Б.Ичинноров: МАЭ үйлчилгээнд халдварт өвчинд шаардлагатай зарцуулах зардал гэж явдаг байгаа. Жишээ нь: Мялзан өвчинд дуудлагаар ажиллах, дээж авах, хорио цээр тогтоох, туслах ажилтан авдаг байгаа.

Сумын Засаг дарга Б.Сугар: Шатаах зуух хоёр хийгдсэн. Нэг нь сумын төвд, нөгөө нь багийн төвд хамгаалах байшинтай тусгаарлах. Тиймээс хортой нөхцөл үлдэхгүй гэж үзэж байгаа.

АСУУЛТ: Д.Данаасүрэн: 1. ЕБС дээр сан техникийн ажил хийгдсэн. Тендерт оролцогчдын чадавх

2. Соёлын төв 30сая төгрөгийн санхүүжилт авсан. 3-н ажлыг задлаад хэлээд өгнө үү? Өөр ажил хийгдсэн харагдаад байна. Тендерт өгөгдсөн зориулалтын дагуу хэрэгжиж байна уу?

ХАРИУЛТ: Б.Түмэндэмбэрэл: 10сая төгрөгийн сангийн засвар хийгдсэн. Орос секц тавьсан барааны үнийг техникийн тодорхойлолтод тусгагдсан дагуу бараа материалаа татаж хэрэгжүүлсэн. ЕБС-аас хяналтын баг гаргаж хяналт тавьж ажилласан. Хариуцсан ажилтан өөрөө оролцож хийсэн учир үр бүтээлтэй ажил болсон гэж үзэж байгаа.

М.Ганжаргал: тендерт зарлагдсан ажилдаа зарцуулагдсан.

САНАЛ: Сан техникч Чинзориг: Цаашид ЕБС-ийн сангийн ажлыг ОНХС –ийн хөрөнгөөр биш Улсын төсвөөр хэрэгжүүлэх нь зүйтэй гэсэн санал хэлэв.

САНАЛ: А.Батдорж: 1. Иргэдээс ирсэн санал болгоныг эрэмбэлэх шаардлагатай байгаа. Жилийн эцэст ОНХС-ийн санал хэлэлцэж байхад нэн шаардлагатай нэмэлт саналуудыг нэмэлтээр оруулж байх нь зүйтэй.

САНАЛ: Д.Данаасүрэн: ЕБС-ийн сан техникийн засвар бараг шаардлагагүй ажил хэрэгжсэн юм бол уу гэсэн санал байна. Улсын төсвөөр хэрэгжүүлэх нь зүйтэй байх.

САНАЛ: Ц.Ганхуяг: ОНХС –аар хэрэгжих ажилд байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах шаардлагатай байна. Хяналтын ажилд ЗДТГ болоод холбогдох байгууллагуудын ажлын хэсэг, ИТХ-ын хяналтын ажлын хэсгийг хоршуулж ажиллуулах нь зүйтэй юм байна. Цаашид хамтарч ажиллах арга замыг сайжруулах шаардлагатай байна. Тендер болоод гэрээлэх ажлын техникийн тодорхойлолтуудыг нээлттэй байлгах нь чухал байна. Бүх зүйлээ төсөвтөө багтааж төсвийг хугацаанд нь 12 сарын 10 -аас өмнө ирүүлэх нь чухал байна шүү.

А.Батдорж: Том төсөв хэрэгжүүлдэг улсын төсвийн байгууллагуудад ОНХС-аар санхүүжүүлэхгүй баймаар юм байна. Улсын төсвийн хөрөнгийн хаагаад байх ажил гарах юм биш үү.

ТАЙЛБАР: П.Сольтогтох хяналтын ажилд ИТХ –ын хяналт, ЗДТГ-ын хяналтын ажлын хэсэг байгуулсан захирамж тус тусдаа байдаг байгаа.

Сумын Засаг дарга Б.Сугар бидний ажлын бичиг хэрэг албан тушаалтнууд тухайн холбогдолтой техникийн тодорхойлолт зураг төсөв асуудлуудыг солилцож ажиллах хэрэгтэй.

ДҮГНЭЛТ: Хурал даргалагч Н.Сайнбилэг: Жил бүр нийтийн сонголыг зохион байгуулж нээлттэй үр дүнд хүрч ажиллахаар шаардлагатай болж байгаа. Ажил арга хэмжээг сайжруулах нь зүйтэй байна.

Сонсгол даргалагч оролцогчдоос асуух асуулт, талбар, санал байхгүй бол нийтийн сонголыг хаах санал гаргаж сонсголын хэлэлцүүлгийг 13.58 цагт хаав.

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:


ИТХ-ЫН АЖЛЫН АЛБАНЫ МЭРГЭЖИЛТЭН



Ц.ЦЭВЭЭНСҮРЭН

ХЯНАСАН:

ИТХ-ЫН АЖЛЫН АЛБАНЫ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА



Н.САЙНБИЛЭГ

